



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.08.13 № 03/1518

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас зарласан НХААГ/20240103556 дугаартай "Каунти маркийн 50 автобусанд тээврийн хэрэгслийн даатгал"-ын үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтад сонирхогч этгээдээс тодруулга гарсантай холбогдуулан хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

Хавсралт 1 хуудастай.



Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар
Удирдлага
Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Даваадорж Батцэцэг
2024.08.13 11:26



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН
ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
Бага тойруу 3, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-11) 32 79 68
Цахим хуудас: www.transport.ub.gov.mn

2024.08.12 № 02/06/1966
танай 2024.08.07 -ны № 03/1481 -т

Албан бичгийн хариу

Танай байгууллагаас 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 03/1481 дугаартай албан бичгийн дагуу Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд нийлүүлэгдсэн Каунти маркийн 50 автобусны тээврийн хэрэгслийн даатгалын үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад оролцох сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариуг хүргүүлж байна.

Ажил үйлчилгээний даалгаврын "Нэмэлт үйлчилгээ"-нд заасан жолоочийн албан журмын даатгалын үйлчилгээнд жолоочийн хариуцлагын албан журмын даатгал болон мэргэшсэн жолоочийн хариуцлагын даатгал хамрагдаж байгаа болно.

Тээврийн хэрэгслийн даатгалын үйлчилгээг гүйцэтгэхээр шалгарсан аж ахуйн нэгж байгууллага нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, мэргэшсэн жолоочийн хариуцлагын даатгалыг гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

Жолоочийн хариуцлагын даатгалын төлбөрийг тухайн даатгуулагч аж ахуйн нэгж байгууллага өөрсдөө хариуцна.



Нийтийн тээврийн бодлогын газар
Захиргаа удирдлагын хэлтэс
Захиргаа удирдлагын хэлтсийн дарга
Зина ЦЭВЭЭНДОРЖ
2024.08.12 18:33